

ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН ТЕСТ

1. “Эрх зүй бол төрийн хүсэл зоригоос ангид жам ёсны болон хүний салшгүй эрхийн тогтолцоо мөн” гэж ямар хандлага үздэг вэ
 - a. Философийн
 - b. Норматив
 - c. Социологийн
 - d. Реалист
2. “Эрх зүй –төрөөс тогтоодоггүй, харин нийгмийн хөгжлөөр хэвшин тогтож, төр нээж байдаг хэм хэмжээ мөн” ямар хандлага үздэг вэ
 - a. Философийн
 - b. Норматив
 - c. Социологийн
 - d. Реалист
3. Эрх зүйн онол
 - a. Байгаа эрх зүйг
 - b. Байх ёстой эрх зүйг
 - c. Эдгээрийг судална
4. Монгол улсад үйлчилж байгаа эрх зүйн бүхий л хэм хэмжээ
 - a. Субъектив эрх
 - b. Эрх зүйн тогтолцоо
 - c. Объектив эрх
5. Эрх зүйн дотоод, хамгий гол, харьцангуй тогтвортой шинж чанарыг тусгасан, түүний нийгэмд эзлэх мөн чанар, зориулалтыг илэрхийлсэн ойлголтыг
 - a. Эрх зүйн чиг үүрэг
 - b. Эрх зүйн үнэт зүйл
 - c. Эрх зүйн мөн чанар
6. Субъектүүдийн тодорхой хэрэгцээг хангах чадварыг
 - a. Эрх зүйн зарчим
 - b. Эрх зүйн үнэт зүйл
 - c. Эрх зүйн мөн чанар гэнэ.
7. Хөдөлмөр ба цалин урамшуулал, гэмт хэрэг ба ял шийтгэлийн хоорондын зохицолын талаарх шаардлага доорх эрх зүйн нийтлэг зарчмын алинаар тодорхойлогдох вэ
 - a. Хууль ёсны
 - b. Гуманизм
 - c. Шударга ёс
8. Эрх зүйн нийгмийн чиг үүрэгт
 - a. Эдийн засгийн
 - b. Хамгаалах
 - c. Улс төрийн
 - d. Экологийн
 - e. Зохицуулалтын
9. Эрх зүйн чиг үүргийн хэрэгжилтийн дараах хэлбэрээс аль нь хууль зүйн шууд нөлөөлөлд хамаарах вэ
 - a. Мэдээллийн нөлөөлөл
 - b. Чиг баримжааны нөлөөлөл
 - c. Эрх зүйн зохицуулалт

10. Эрх зүйн эх сурвалж нь материаллаг утгаар
 - a. Эрх зүйн бүхий л хэм хэмжээ
 - b. Эрх зүйн хэмжээг нөхцөлдүүлсэн хүчин зүйл
 - c. Зөв хариулт алга
11. “Шүүхийн жишиг”, “хэм хэмжээний гэрээ” гэсэн ойлголт дараах нэр томъёоны алинд хамаарах вэ
 - a. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах акт
 - b. Эрх зүйн эх сурвалж
 - c. Эрх зүйг хэрэглэх акт
 - d. Зөв хариулт алга
12. Эрх зүйн дараах хэлбэрээс алийг эрх зүйн баримт бичигт текст хэлбэрээр бичдэггүй вэ
 - a. Хэм хэмжээчилсэн эрх зүйн акт
 - b. Эрх зүйн заншил
 - c. Эрх зүйн жишиг
13. Номлол эрх зүйн аль бүлд эрх зүйн гол эх сурвалж болдог вэ
 - a. Мусульманы
 - b. Ром-германы
 - c. Англосаксоны
14. Эрх зүйн дараах хэлбэрээс аль нь монгол улсад эрх зүйн эх сурвалж болдоггүй вэ
 - a. Шүүхийн жишиг
 - b. Хэм хэмжээ агуулсан гэрээ
 - c. Эрх зүйн заншил
15. Эрх зүйг хувийн болон нийтийн гэж ангилдаг эрх зүйн тогтолцоо
 - a. Эх газрын
 - b. Англоамерикийн
 - c. Орчин үеийн
 - d. Хөрөнгөтний
16. Common law тогтолцоонд нийтлэг эрх зүй гэдэгт
 - a. Шүүхийн жишиг
 - b. Заншил
 - c. Эрх зүйн нийтлэг зарчим
17. Хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулж байгаа зан үйлийн журмыг
 - a. Тушаал
 - b. Нийгмийн хэм хэмжээ
 - c. Нэг бүрчилсэн хэм хэмжээ
18. Нийгмийн хэм хэмжээ ямар шинжээрээ техникийн хэм хэмжээнээс ялгагддаг вэ
 - a. Үүссэн цаг хугацаагаараа
 - b. Зохицуулж байгаа зүйлээрээ
 - c. Бэхжүүлсэн хэлбэрээрээ
19. Зан үйлийн эдгээр зохицуулалтаас аль нь хэм хэмжээчилсэн бэ
 - a. Заншлын зохицуулалт
 - b. Үнэт зүйлийн зохицуулалт
 - c. Мэдээлэлийн зохицуулалт
20. Эрх зүй болон ёс суртахууны хоорондын харилцаанд ямар бүрдэл хэсгүүдийг агуулдаг вэ
 - a. Нэгдэл, ялгаа, харилцан үйлчлэл, зөрчил
 - b. Ялгаа, сөргөлдөөн, зөрчилдөөн, зөрчил
 - c. Нэгдэл, харилцан үйлчлэл, зөрчил, сөргөлдөөн

21. Үйлчилж байгаа болон үйлчлэх ёстой эрх зүйн харилцаанд илэрч байга эрх зүйн үзэл санаа, онол, үзэл баримтлал, мэдрэмж, сэтгэл хөдлөл, сэтгэл санааны төлөв байдлын нийлбэр цогцыг
 - a. Эрх зүйн соёл
 - b. Эрх зүйн ухамсар
 - c. Эрх зүйн хүмүүжил гэнэ.
22. Эрх зүйн ухамсрын бүтцэд хамаарах элемент
 - a. Эрх зүйн үзэл суртал ба эрх зүйн сэтгэл судлал
 - b. Эрх зүйн үзэл суртал ба эрх зүйн идэвхтэй байдал
 - c. Эрх зүйд нийцсэн зан үйл ба эрх зүйн зөрчил
23. Монгол дахь эрх зүйн нигилизмын шалтгаан
 - a. Улс төрийн идэхгүй байдал
 - b. Улс төрийн радикализм
 - c. Иргэдийн эрх зүйн ухамсрын доогуур төвшин
 - d. Түүхэн уламжлал
24. Эрх зүйн хүрээнд хүний бүтээсэн бүхий л үнэт зүйлүүдийн нийлбэр цогц
 - a. Хууль тогтоох ажиллагаа
 - b. Хууль зүйн практика
 - c. Эрх зүйн соёл
 - d. Үндсэн хууль
25. Нийгмийн эрх зүйн соёлыг тодорхойлдог үзүүлэлт
 - a. Хууль тогтоомж, эрх зүйн ухамсар, хууль ёс, эрх зүйн дэг журам, хууль зүйн техникийг боловсронгуй болгох төвшин
 - b. Эрх зүйн мэдлэг, ойлголт, эрх зүйг дээдлэх, хууль биелүүлэх зуршил
 - c. Эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн харилцаа, эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх
26. Хууль тогтоох үйл ажиллагаанд эрх зүйн ухамсар ямар үүрэг гүйцэтгэдэг вэ
 - a. Хууль тогтоох үйл ажиллагааны шалтгаант чанар
 - b. Хууль зүйн техникийн нэг хэрэгсэл
 - c. Эрх зүйн акт батлах процедурыг тодорхойлдог
27. Хуулийн дээд хүчин чадал нь
 - a. Нийтээр сахих шинж чанар
 - b. Аливаа эрх зүйн акт хуульд заавал нийцэж байх шинж чанар
 - c. Төрийн эрх бүхий байгууллага баталж гаргасан
 - d. Төрийн албадлагаар хамгаалагдсан
28. Эрх зүйн тогтолцооны анхдагч элемент
 - a. Салбар эрх зүй
 - b. Эрх зүйн хэм хэмжээ
 - c. Эрх зүйн институт
29. Хууль тогтоомжийн болон эрх зүйн тогтолцоо ямар хамааралтай вэ
 - a. Хэсэг ба бүхэл
 - b. Агуулга ба хэлбэр
 - c. Шалтгаан ба үр дагавар
30. Эрүүгийн эрх зүйд холбогдох эрх зүйн зохицуулалтын арга
 - a. Зөвлөх
 - b. Императив
 - c. Диспозитив
31. Ямар субъектэд эрх зүйн чадвар , чадамж нэгэн зэрэг үүсдэг вэ
 - a. Хулийн этгээд
 - b. Хувь этгээд

- с. Эдгээрт болон бусад этгээдэд
- 32. Тодорхой этгээдэд хамаарч буй эрхийг
 - а. Позитив
 - б. жам ёсны
 - с. субъектив
- 33. Эрх зүйн харилцаанд субъектив эрх эдэлж, хууль зүйн үүрэг хүлээж буй этгээдийг
 - а. Эрх зүйн этгээд
 - б. Эрх зүйн харилцааны субъект
 - с. Эрх зүйн зөрчлийн субъект
 - д. Аль нь ч биш
- 34. Хүсэл зоригийн шинж чанараар нь хууль фактыг
 - а. Үйл явдал ба үйлдэл
 - б. Хууль зүйн дагуух болон хууль зүйн бус
 - с. Хууль зүйн акт ба хууль зүйн үйлдэл
- 35. Эрх зүйн этгээдийн хүсэл зориг, ухамсраас үл хамааран үүссэн хууль зүйн факт
 - а. Гэр бүл болох
 - б. Бусдын өмчийг шатааж устгах
 - с. Даатгагдсан эд зүйл үерт автаж устах
- 36. Өмчийн харилцаа эрх зүйн харилцааны аль хэв маягт хамаарах вэ
 - а. Нийтлэг зохицуулалтын
 - б. Харьцангуй
 - с. Туйлын
 - д. Зөв хариулт алга
- 37. Эрх зүйг хэрэгжүүлэх үйлдлийнх нь шинж чанараар эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн хэлбэрийг юу гэж ангилдаг вэ
 - а. Хариуцлага хүлээлгэх, төлөөлүүлэх
 - б. Мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэх
 - с. Тайлбарлах, өөрчлөх, шинэчлэх
 - д. Мөрдөх, сахих, хэрэгжүүлэх
- 38. Заавал хэрэгжүүлэх хэм хэмжээ ямар хэлбэрээр хэрэгждэг вэ
 - а. Хэрэглэх
 - б. Хэрэгжүүлэх
 - с. Мөрдөх
 - д. Дээдлэх
- 39. Хэрэг, маргааныг шийдвэрлэсэн шүүгчийн шийдвэр
 - а. Хууль хэрэглэсэн акт
 - б. Хууль тайлбарласан акт
 - с. Хууль баримталсан акт
 - д. Эдгээрийн нэгдэл
- 40. Хууль зүйн хариуцлага хүлээлгэх бодит үндэслэл
 - а. Хариуцлага хүлээлгэх эрх зүйн хэм хэмжээ байх
 - б. Эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүн
 - с. Эрх зүйг хэрэглэх акт байх
- 41. Хууль зүйн хариуцлагын үндсэн чиг үүрэг
 - а. Зохицуулах ба хамгаалах
 - б. Эрхийг хамгаалах ба нийгмийн
 - с. Шийтгэж, хүмүүжүүлэх
- 42. Дор дурьдсан эрх зүйн үзэл санаанаас хууль ёсны зарчимд аль хамаарах вэ
 - а. Хууль дээдлэх

- b. Хууль нэгдмэл байх
 - c. Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох
 - d. Эрх, үүрэг тэнцвэртэй байх
43. Хууль ёс, ардчилалын хоорондын хамаарал
- a. Ардчилал хөгжих тусам хууль ёс багасах
 - b. Хууль ёс хөгжих тусам ардчилал хумигдах
 - c. Хууль ёс – ардчиллын үндэс, харин ардчилал –хууль ёсны зайлшгүй нөхцөл
44. “Эрх зүйн дэг журам”, “нийгмийн дэг журам” ойлголтын ялгаа
- a. Нийгмийн дэг журам эрх зүйн дэг журмын нэг бүрэлдэхүүн хэсэг
 - b. Эдгээр нь ижил ойлголт
 - c. Эрх зүйн дэг журам нь нийгмийн дэг журмын бүрэлдэхүүн хэсэг
 - d. Эдгээр нь төрөл, дүрсийн бус ойлголт
45. “Хууль ёс”, “эрх зүйн дэг журам” ойлголтын харилцан хамаарал
- a. Эрх зүйн дэг журам – хууль ёсны үндэс
 - b. Эрх зүйн дэг журам- эрх зүйн харилцаанд оролцогчдын өдөр тутмын зан үйлийн хууль ёсны шаардлага
 - c. Хууль ёс –эрх зүйн дэг журмын нэг бүрэлдэхүүн хэсэг
46. Эдгээрээс аль нь хууль ёсны хууль зүйн баталгаа вэ
- a. Хууль зүйн техник
 - b. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох
 - c. Хууль, шүүхийн өмнө иргэд эрх тэгш байх
47. Эрх зүйн зохицуулалтын үндсэн механизм
- a. Эрх зүйн дэг журам ба хууль ёс
 - b. Эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн харилцаа, эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх акт
 - c. Эрх зүйн хэлбэр, чиг үүрэг, зарчим
 - d. Эрх зүйн соёл, хүмүүжил
48. Эрх зүйн зохицуулалтын арга
- a. Тунхаглал, программ, зөвлөмж
 - b. Хориглолт, зөвшөөрөл, хууль ёсны үүрэг
 - c. Итгэл үнэмшил, албадлага
49. Маргаан шийдвэрлэн гаргаж буй тайлбар
- a. Хэм хэмжээний
 - b. Аутентик
 - c. Системчилсэн
 - d. Казуал
50. Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлаж болох уу
- a. Хэзээ ч болохгүй
 - b. Шүүхийн журмаар хязгаарлаж болно
 - c. Иргэний зөвшөөрөлийн үндсэн дээр хязгаарлаж болно
 - d. Иргэд хоорондоо зөвшилцөн хязгаарлаж болно